



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/161/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор Д.Цэрэнханд Утас: 99086371 Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn</p>
---	---



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 24 № 88

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ш.ЭРДЭНЭБАТ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймагын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд Хурлын даргын зөвлөхийн орон тоо илүү ажиллуулж 42,862.3 мянган төгрөгийн цалин хөлс олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан,
- Тус байгууллага нь үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралгүй "Хуурын эгшиг-2025" яруу найргийн наадам, Баруун болон хангай бүсийн өсвөрийн төгөлдөр хуурчдын 5 дугаар уралдаан, Модон могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан өндөр настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнүүдэд 63,072.9 мянган төгрөгийг зарцуулсан,
- Хууль тогтоомжид тусгайлан эрх олгоогүй байхад бараа үйлчилгээний бусад зардлын эдийн засгийн ангиллаас бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зориулалт

822505000251

арга хэмжээний зардалд 128,550.2 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр Хурлын даргын захирамжаар 83,312.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан,

- Засгийн газрын баталсан Хурлын ажлын албаны орон тооны хязгаараас 8 орон тоо илүү ажиллуулсан,
- Автомашин худалдан авах тендер шалгаруулахдаа журам зөрчиж "Ланд-300 авто машин нийлүүлэх" гэж зарлаж, санхүүжилтийг үе шатаар олгоогүй гэрээний үнийн дүн 238,000.0 мянган төгрөгийг 1 удаагийн гүйлгээгээр шууд шилжүүлсэн,
- Төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг хуваан босго үнээс доогуур дүнгээр хэсэгчлэн баталж, байгууллагын дотоод засвар хийхэд 62,790.5 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн,
- Тайлант онд 180,363.2 мянган төгрөгийн өглөг, 609.9 мянган төгрөгийн авлага үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 5 дугаар зүйлийн 5.3, 5.4, 15 дугаар 15.1.3, 15.1.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 376 дугаар "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын ивээл дор "Хуурын эгшиг-2025" яруу найргийн наадмыг зохион байгуулж, орсон орлогыг Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн өрх толгойлсон багшид хандивласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд гүйцэтгэлээр 1,939,852.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 61.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бусад асуудал

Тайлант онд 6 зорилго, 11 зорилт, 44 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 40 арга хэмжээг бүрэн, 2 арга хэмжээг 75 хувь, 2 арга хэмжээг 50 хувь буюу нийт дүнгээр 96.6 хувиар хэрэгжснээр үнэлсэн байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Т. ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,413,448.00	36,683,448.00
33	АВЛАГА	609,948.00	609,948.00
335	Бусад авлага	609,948.00	609,948.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	609,948.00	609,948.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,803,500.00	36,073,500.00
354	Хангамжийн материал	30,803,500.00	36,073,500.00
35410	Бичиг хэргийн материал	105,000.00	105,000.00
35420	Аж ахуйн материал	29,337,250.00	34,607,250.00
35450	Барилгын засварын материал	1,361,250.00	1,361,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	112,750,165.78	329,508,681.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	112,750,165.78	329,508,681.35
392	Биет хөрөнгө	112,610,165.78	329,468,681.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,000,000.00	316,276,278.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(178,055,555.80)	(60,798,098.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,493,490.00	104,888,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,711,653.00)	(66,462,535.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,014,800.00	54,890,985.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,499,415.42)	(19,510,687.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	368,500.00	368,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(184,249.92)
393	Биет бус хөрөнгө	140,000.00	40,000.04
39301	Программ хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(60,000.00)	(159,999.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	144,163,613.78	366,192,129.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,460,829.34	180,363,202.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,460,829.34	180,363,202.00
413	Өглөг	32,460,829.34	180,363,202.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	20,768,300.00
4136	Бусад өглөг	(0.00)	159,594,902.00
41361	Байгууллагад төлөх өглөг	(0.00)	157,067,180.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	2,527,722.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	111,702,784.44	185,828,927.35
51	Засгийн газрын хувь оролцоо	111,702,784.44	185,828,927.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,211,354.00	122,211,354.00
51101	Өмч: - төрийн	122,211,354.00	122,211,354.00
512	Хуримтлагдсан үр дүн	(13,104,678.39)	61,021,464.52
51210	Өмнөх үеийн үр дүн	59,663,419.18	(13,104,678.39)
51220	Тайлант үеийн үр дүн	(72,768,097.57)	74,126,142.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,596,108.83	2,596,108.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	144,163,613.78	366,192,129.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,262,618,060.00	1,947,852,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,255,369,200.00	1,947,852,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,000,000.00	8,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,000,000.00	8,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,201,369,200.00	1,939,852,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,201,369,200.00	1,939,852,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,335,351,157.57	1,873,726,657.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,335,351,157.57	1,873,726,657.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	929,308,236.69	1,365,440,063.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	537,714,655.74	734,015,084.94
210101	Үндсэн цалин	345,122,523.13	451,933,314.72
210102	Нэмэгдэл	174,465,857.15	228,326,054.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,126,275.46	44,905,673.27
210104	Урамшуулал	-	8,850,042.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,472,265.30	91,947,414.56
210201	Тэтгэврийн даатгал	38,601,022.00	62,509,288.67
210202	Тэтгэмжийн даатгал	4,267,310.84	7,368,693.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,100,655.41	3,684,347.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,100,655.41	3,677,017.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,402,621.64	14,708,067.92
2104	Хангамж, бараа материалын зардал	36,806,235.42	83,152,318.00
210401	Бичиг хэрэг	5,954,000.00	4,736,150.00
210402	Тээвэр, шатахуун	26,960,306.00	74,278,676.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,819,779.42	4,137,492.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,074,750.00	80,871,558.44
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,230,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	10,844,750.00	80,671,558.44
2107	Томилолт, зочны зардал	24,040,000.00	29,199,050.00
210702	Дотоод албан томилолт	24,040,000.00	29,199,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,791,532.00	159,705,082.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,136,680.00	153,037,750.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,000,000.00	6,021,480.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	205,852.00	205,852.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,408,798.23	186,549,555.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,550,000.00	102,898,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,635,900.00	21,227,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,222,898.23	62,423,647.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	406,042,920.88	508,286,593.72
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	379,638,282.00	289,999,300.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	379,638,282.00	289,999,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,577,557.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,827,081.88	217,687,293.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,827,081.88	217,687,293.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(72,733,097.57)	74,126,142.91

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(72,733,097.57)</u>	<u>74,126,142.91</u>
---	-------------------------	------------------------	----------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,257,324,200.00</u>	<u>1,947,852,800.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,255,369,200.00</u>	<u>1,947,852,800.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,000,000.00	8,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,000,000.00	8,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,201,369,200.00	1,939,852,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,201,369,200.00	1,939,852,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,241,970,700.00</u>	<u>1,682,786,915.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,241,970,700.00</u>	<u>1,682,786,915.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>835,927,779.12</u>	<u>1,324,500,321.28</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,253,826.40	766,475,914.28
210101	Үндсэн цалин	312,661,693.79	484,394,144.06
210102	Нэмэгдэл	174,465,857.15	228,326,054.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,126,275.46	44,905,673.27
210104	Урамшуулал	-	8,850,042.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,472,265.30	91,947,414.56
210201	Тэтгэврийн даатгал	38,601,022.00	62,509,288.67
210202	Тэтгэмжийн даатгал	4,267,310.84	7,368,693.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,100,655.41	3,684,347.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,100,655.41	3,677,017.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,402,621.64	14,708,067.92
2104	Хангамж, бараа материалын зардал	34,845,255.42	67,223,818.00
210401	Бичиг хэрэг	5,954,000.00	3,235,950.00
210402	Тээвэр, шатахуун	24,999,326.00	59,999,676.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,819,779.42	3,988,192.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,339,000.00	100,090,114.44
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,230,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	13,109,000.00	99,890,114.44
2107	Томилолт, зочны зардал	24,040,000.00	22,859,050.00
210702	Дотоод албан томилолт	24,040,000.00	22,859,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,791,532.00	158,883,602.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,136,680.00	152,237,750.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,000,000.00	6,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	205,852.00	205,852.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,000.00	440,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,185,900.00	117,020,408.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,550,000.00	101,398,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,635,900.00	15,621,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	406,042,920.88	358,286,593.72
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	379,638,282.00	139,999,300.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	379,638,282.00	139,999,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,577,557.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,827,081.88	217,687,293.72
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,827,081.88	217,687,293.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>15,353,500.00</u>	<u>265,065,885.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,318,500.00	265,065,885.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,318,500.00	265,065,885.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,318,500.00	265,065,885.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,318,500.00	265,065,885.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(15,318,500.00)</u>	<u>(265,065,885.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	(13,104,678.39)	111,702,784.44
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	(13,104,678.39)	111,702,784.44
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	(13,104,678.39)	111,702,784.44
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	(13,104,678.39)	111,702,784.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	(13,104,678.39)	111,702,784.44
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	74,126,142.91	74,126,142.91
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	61,021,464.52	185,828,927.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,939,852,800.00	1,939,852,800.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,699,852,800.00	1,699,852,800.00	-	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,408,152,800.00	1,341,566,206.28	66,586,593.7	95.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,961,300.00	766,475,914.28	(2,514,614.3)	100.3
210101	Үндсэн цалин	663,961,300.00	484,394,144.06	179,567,155.9	73.0
210102	Нэмэгдэл	100,000,000.00	228,326,054.05	(128,326,054.1)	228.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	44,905,673.27	(44,905,673.3)	
210104	Урамшуулал	-	8,850,042.90	(8,850,042.9)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,495,000.00	91,947,414.56	3,547,585.40	96.3
210201	Тэтгэврийн даатгал	64,936,600.00	62,509,288.67	2,427,311.3	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	7,639,600.00	7,368,693.97	270,906.0	96.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,819,800.00	3,684,347.00	135,453.0	96.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,819,800.00	3,677,017.00	142,783.0	96.3
210205	Эрүүл мэндийн даатгал	15,279,200.00	14,708,067.92	571,132.1	96.3
2104	Хангамж, бараа материалын зардал	69,802,500.00	67,223,818.00	2,578,682.0	96.3
210401	Бичиг хэрэг	5,088,000.00	3,235,950.00	1,852,050.0	63.6
210402	Тээвэр, шатахуун	60,000,000.00	59,999,676.00	324.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,214,500.00	3,988,192.00	226,308.0	94.6
210404	Ном, хэвлэл	500,000.00	-	500,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	126,000,000.00	125,155,999.44	844,000.6	99.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,000,000.00	25,265,885.00	734,115.0	97.2
210604	Урсгал засвар	100,000,000.00	99,890,114.44	109,885.6	99.9
2107	Томилолт, зочны зардал	29,209,000.00	22,859,050.00	6,349,950.0	78.3
210702	Дотоод албан томилолт	29,209,000.00	22,859,050.00	6,349,950.0	78.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,134,800.00	158,883,602.00	6,251,198.0	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157,870,800.00	152,237,750.00	5,633,050.0	96.4
210803	Даатгалын үйлчилгээ	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	205,852.00	14,148.0	93.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	-	44,000.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	440,000.00	560,000.0	44.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,550,200.00	109,020,408.00	49,529,792.0	68.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,550,200.00	101,398,908.00	27,151,292.0	78.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,000,000.00	7,621,500.00	22,378,500.0	25.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,700,000.00	358,286,593.72	(66,586,593.7)	122.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	290,000,000.00	139,999,300.00	150,000,700.0	48.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	290,000,000.00	139,999,300.00	150,000,700.0	48.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,700,000.00	600,000.00	1,100,000.00	35.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	600,000.00	1,100,000.00	35.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	240,000,000.00	240,000,000.00	-	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	240,000,000.00	240,000,000.00	-	100.0
223001	Бусад хөрөнгө	240,000,000.00	240,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,939,852,800.00	1,939,852,800.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,939,852,800.00	1,939,852,800.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,939,852,800.00	1,939,852,800.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,000,000.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 436,370.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Ланд 300 автомашинд авсан гаднах хуулга 6,276.3 мянган төгрөгөөр, автомашины хөгжим 2,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч хөрөнгийг орлого аваагүй шууд зардлаар тайлагнасан,
- Хувь хүний орлогын албан татварын тайланг 1,455.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасныг залрууллаа.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 60,903.1 мянган төгрөгийн 1 мэдээлэл, зарлагын 10,816.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, төсөв өмч хөрөнгө зарцуулах 114,191.9 мянган төгрөгийн 25 тушаал шийдвэр, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 240,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээний 13,030.9 мянган төгрөгийн 1 мэдээлээгүйг тус тус нөхөн байршууллаа.

Залруулагдаагүй нийт 426,965.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 426,965.7 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг: Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд Хурлын даргын зөвлөхийн орон тоо илүү ажиллуулж 42,862.3 мянган төгрөгийн цалин хөлс олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 5 дугаар зүйлийн 5.3-т "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно", 5.4-т "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөвлөх чиг үүрэг бүхий орон тоонд ажиллаж байгаа албан хаагчийг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хоёр. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой

Илрүүлэлт: Тус байгууллага нь үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралгүй "Хуурын эгшиг-2025" яруу наадам, Баруун болон хангай бүсийн өсвөрийн төгөлдөр хуурчдын 5 дугаар уралдаан зохион байгуулах, Модон могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан 70 дээш өндөр настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүрээнд 63,072.9 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд

хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд төсвийг зарцуулахгүй байх.

Гурав. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага хууль тогтоомжид тусгайлан эрх олгоогүй байхад бараа үйлчилгээний бусад зардал (210901) эдийн засгийн ангиллаас бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө (81104)-ийн зориулалт арга хэмжээний зардалд 128,550.2 мянган төгрөгийг төлөвлөж, Хурлын даргын захирамжаар 83,312.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хурлын даргын захирамжаар төсөв зарцуулж буй зөрчлийг таслан зогсоож, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах.

Дөрөв. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын баталсан Хурлын ажлын албаны орон тооны хязгаараас 8 орон тоо илүү ажиллаж байгаа нь Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай тогтоол"-ын 1-т "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан ..., Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 12 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай", 4-т "Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны цалингийн санг тогтоохдоо Засгийн газраас баталсан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт, төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг тус тус мөрдөж ажиллахыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын албаны бүтэц, орон тоог эрх бүхий этгээдээс тогтоосон хязгаарт багтаан батлуулан мөрдөж ажиллах.

Тав. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Автомашины худалдан авах ажиллагааны тендер шалгаруулахдаа "Ланд-300 авто машин нийлүүлэх" гэж нэр төрөл заан зарлаж, санхүүжилтийг үе шатаар олгоогүй гэрээний үнийн дүн болох 238,000.0 мянган төгрөгийг 1 удаагийн гүйлгээгээр шууд шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно", 12.5-т "Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.", 39 дүгээр зүйлийн 39.3.3-т "төлбөрийн нөхцөл, хугацаа" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан, мөрдөж ажиллах.

Зургаа. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг хуваан босго үнээс доогуур дүнгээр хэсэгчлэн баталж, байгууллагын дотоод засвар хийхэд 62,790.5 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцсэн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр босго үнээс дээш давсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж ажиллах.

Долоо. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 180,363.2 мянган төгрөгийн өглөг, 609.9 мянган төгрөгийн авлага үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 70 дугаар зүйлийн 70.5-т "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд тусгасан өр авлагыг барагдуулж, ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нээгээл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 60,903.1 мянган төгрөгийн 1 мэдээлэл, зарлагын 10,816.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, төсөв өмч хөрөнгө зарцуулах 114,191.9 мянган төгрөгийн 25 тушаал шийдвэр, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 240,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээний 13,030.9 мянган төгрөгийн 1 мэдээлэл мэдээлээгүй.	1	426,639.1	1	426,639.1	-	-	1	426,639.1	-	-	-	-
	Ланд 300 автомашинд авсан гаднах хуулга 6,276.3 мянган төгрөгөөр, автомашины хөгжим 2,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч хөрөнгийг орлого аваагүй шууд зардлаар тайлагнасан.	1	8,276.3	-	-	1	8,276.3	1	8,276.3	-	-	-	-
	Хувь хүний орлогын албан татварын тайланг 1,455.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	1,455.1	-	-	1	1,455.1	1	1,455.1	-	-	-	-
	Дүн	3	436,370.5	1	426,639.1	2	9,731.4	3	436,370.5	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Тайлант онд Хурлын даргын зөвлөхийн орон тоо илүү ажиллуулж 42,862.3 мянган төгрөгийн цалин хөлс олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	42,862.3	-	-	-	-	1	42,862.3	-	-
	Тус байгууллага нь үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралгүй "Хуурын эгшиг-2025" яруу наадам, Баруун болон хангай бүсийн өсвөрийн төгөлдөр хуурчдын 5 дугаар уралдаан зохион байгуулах, Модон могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан 70 дээш өндөр настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүрээнд 63,072.9 мянган төгрөгийг зарцуулжээ.	1		-	-	-	-	1	-	-	-
	Тус байгууллага хууль тогтоомжид тусгайлан эрх олгоогүй байхад бараа үйлчилгээний бусад зардал (210901)-ийн эдийн засгийн ангиллаас бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө (81104)-ийн зориулалт арга хэмжээний зардалд 128,550.2 мянган төгрөгийг төлөвлөж, Хурлын даргын захирамжаар 83,312.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.	1	83,312.9	-	-	-	-	1	83,312.9	-	-

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Засгийн газрын баталсан Хурлын ажлын албаны орон тооны хязгаараас 8 орон тоо илүү ажиллуулсан.	1		-	-	-	1	-	-	-
	Автомашины худалдан авах ажиллагааны тендер шалгаруулахдаа журам зөрчиж "Ланд-300 авто машин нийлүүлэх" гэж зарлаж, санхүүжилтийг үе шатаар олгоогүй гэрээний үнийн дүн болох 238,000.0 мянган төгрөгийг 1 удаагийн гүйлгээгээр шууд шилжүүлсэн.	1	238,000.0	-	-	-	1	238,000.0	-	-
	Төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг хуваан босго үнээс доогуур дүнгээр хэсэгчлэн баталж, байгууллагын дотоод засвар хийхэд 62,790.5 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.	1	62,790.5	-	-	-	1	62,790.5	-	-
	Тайлант онд 180,363.2 мянган төгрөгийн өглөг, 609.9 мянган төгрөгийн авлага үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй.	1	-	-	-	-	1	-	-	-
дүн		7	426,965.7	-	-	-	7	426,965.7	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		